



Манай амбулаторын хэсэг анх 1955 онд эхчүүд, эмэгтэйчүүдэд зовлогоо огох кабинет хэлбэрээр байгуулагдан үйл ажиллагаагаа эхэлсэн нь Монгол улсын хэмжээнд эх, эмэгтэйчүүдэд амбулаторын тусламж үйлчилгээ анх үзүүлж эхэлсэн үйл явдал болжээ. Энэхүү тусламж үйлчилгээ цаашид оргожин 1982 он гэхэд 16 хэсэгтэй, 80 гаруй эмч, эмнэлгийн ажилтантай, лаборатори, эмийн сан, физик эмчилгээ, рентгентэй, 1981 оноос “АЛОКА” фирмийн аппарат монгол улсад орж ирснээр эхо-ны кабинеттай, биеийн тамир эмчилгээтэй “Тов зовлогоо огох газар” болж бэхжин хөгжжээ. Гэвч зах зээлийн ороо бусгай байдлаас шалтгаалан 1992 онд тухайн үеийн хотын эрүүл мэндийн газрын шийдвэрээр зовлогоо огох газрыг дүүргүүдийн харъяанд ажиллуулах болсон тул тус амаржих газрын харъяанаас гарчээ. 2013 онд тус амаржих газрын шинэ барилга ашиглалтанд орсонтой холбоотойгоор 2013-оны 6-р сарын 14 –ны одрийн еронхий эмчийн “Бүтэц зохион байгуулалт шинэчлэх тухай” А/55 тоот тушаалын дагуу дахин байгуулагдсан.

2018 онд нийт 20 эмч, ажилтантай, жирэмсний хяналтын 3, эмэгтэйчүүдийн 1, ургийн зүрхний бичлэгийн 1, уродинамикийн 1, дотрын 1, одрийн эмчилгээний 1, урологийн эмчилгээний 1, нохон үржихүйн 1 кабинеттайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2013 оноос хойш 190 000 гаруй эхчүүд, эмэгтэйчүүдэд тусламж үзүүлээд байна.

Тус амбулаторын тасаг нь 2014 онд КНАГ-ын шилдгийн шилдэг хамт олон, 2015 онд НОАГ-ыны шилдэг хамт олон, 2015 онд НОАГ-ын оны шилдэг чанарын багаар удаа дараа шалгаран ажилласан ажилсаг хамт олон юм.

